

### ДОКТОР Т.БААСАНСҮРЭНГИЙН «МОНГОЛД ЧӨЛӨӨТ АРДЧИЛСАН ХЭВЛЭЛ БҮРЭЛДЭН ТӨЛӨВШСӨН НЬ» БҮТЭЭЛИЙН ТУХАЙД

Ч.Чойсамба\*

\* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), дэд профессор

**Түлхүүр үг:** Т.Баасансүрэн, сэтгүүл зүйн түүх бичлэг, Монголын сэтгүүл зүйн түүхийн үечлэл

Монголын сэтгүүл зүйн 100 жилийн түүхийг тоймлон харуулсан таван боть бүтээлийг Тугалхүүгийн Баасансүрэн туурвиж, энэ салбарыг, ер нь Монголын түүхийг сонирхдог хэн бүхэнд зориулж гаргажээ. Т.Баасансүрэн бол сэтгүүл зүй, шинжлэх ухаан, улс төрд өөртөө гэрэлт цамхаг босгосон, цойлон гарч ирсэн авьяаслаг сэтгүүлч, чадварлаг зохиолч, шилдэг зохион байгуулагч, голыг нь онож хэлдэг шүүмжлэгч, учгийг нь олж бичдэг эрдэмтэн, хүндтэй дипломатч юм.

Т.Баасансүрэн зүгээр нэг түүх өгүүлэхийг хүссэнгүй. Тэрээр үнэлэлт дүгнэлт өгч, учир шалтгааныг тайлж, цаашдын төлөвийг нийгэм-цаг үеийн онцлог, хүний хүчин зүйлтэй холбож өгүүлжээ.

Хоёр боть бүхий «XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл» хэмээх тэргүүн дэвтэрт Т.Баасансүрэн Монголын анхны чөлөөт хэвлэл «Шинэ толь хэмээх бичиг», тус сонины үзэл санааг үргэлжлүүлсэн «Нийслэл хүрээний сонин бичиг», мөн Ардын засгийн үед гарч байсан «Бюллетень монгольского телеграфного агентства», «Хураангуй сэтгүүл» сонины нийтлэлийн бодлого, онцлог, ач холбогдол, нийгэмд үзүүлсэн нөлөө зэрэг асуудлыг

тодорхой жишээ баримтан дээр тулгуурлаж тусгасан байна.

Монголын сэтгүүл зүйн үүсэл, хөгжлийн асуудлыг XX зууны манай нийгмийн амьдралд гарсан үндсэн эргэлтийн шинжтэй хоёр том үйл явдалтай судлаач Т.Баасансүрэн холбож үзжээ. 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнөөр эхэлсэн тусгаар тогтнолын төлөөх монголчуудын тэмцэл 1921 онд ардын хувьсгалын ялалтаар өндөрлөнөөр шинэ Монгол улс байгуулагдсан юм. Энэхүү тэмцэлд анхны чөлөөт болон хувьсгалт хэвлэлүүд нэн чухал үүрэг гүйцэтгэснийг судлаач Т.Баасансүрэн нэр бүхий хэвлэлийн нийтлэлийн жишээн тод томруун гаргаж иржээ.

«Шинэ толь хэмээх бичиг» нь «Монголын нийгэмд өрнөсөн тэр үеийн эрх чөлөөний төлөөх тэмцэл хөдөлгөөний тэргүүлэгч зарч, урагш уриалан дуудагч бүрээч нь байсан», «Шинэ сонин бүхнийг Монгол оронд түгээн дэлгэрүүлж, хамгийн тэргүүний дэвшилтэт үзэл санааг номлогч чөлөөт хэвлэл болж чадсан», «Ж.Цэвээн тэргүүтэй ... сэтгүүлчид XX зууны Монголын нийгмийн оюун санааны охь дээжийг ... сонинхоо гал тогоонд хандлан дээжилж, түмэн олон монголчуудынхаа сонорыг мялааж, нүдийг нээж, хүн ардын ухааныг ундруулж, уралдуулж эхэлжээ» гэж судлаач оновчтой онцолж, базаж дүгнэснийг хүлээн зөвшөөрөхгүй байхын аргагүй.



«Шинэ толь хэмээх бичиг»-ийн нийтлэлийг Т.Баасансүрэн танин мэдүүлж, соён гэгээрүүлэхэд чиглэгдсэн, Монгол улс, түүний улс төр, эдийн засгийн тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд чиглэгдсэн, олон улсын байдлыг мэдээлэхэд чиглэгдсэн гэсэн хэсгүүдэд хувааж, агуулгын задлан шинжилгээ хийж, орчин үеийн сэтгүүл зүйд тавигддаг шаардлагын үүднээс дүгнэлт өгсөн байна.

«Нийслэл хүрээний сонин бичиг»-ийн нийтлэлийн бодлого, сэтгүүлчдийн ур чадвар, бичлэгийн төрөл, зүйлийг судлахдаа Т.Баасансүрэн мөн л тухайн нийгэм-цаг үеийн онцлогтой холбож тайлбарлажээ. Тэгэхдээ тус сонин «сөрөг хүчний байр сууринаас аливаа асуудалд хандаж, “дөрөв дэх засаглал”-ын үүргийг XX зууны эхэн үеийн хүнд хэцүү нөхцөл байдалд гүйцэтгэж чадаж байсан байна. Энэ бол гайхамшиг мөн» гэж дүгнэхийн сацуу «өнөөдрийн төвшнээс авч үзэхэд “Нийслэл хүрээний сонин бичиг” нь “Шинэ толь хэмээх бичиг”-ийн нэгэн адил сэтгүүл зүйн ихэнх шаардлагыг хангаж чадсан хэвлэл байсан байна. Үнэн бөгөөд бодитой байх зарчим, хүнлэг бөгөөд энэрэнгүй байх зарчим, ардчилсан хийгээд олон нийтэч байх зарчим, шинжлэх ухааны үндэстэй бөгөөд амьдралтай нягт холбоотой байх зарчим, тэр ч битгий хэл шуурхай бөгөөд хүртээмжтэй байх зарчим (тухайн цаг үеийн нөхцөл байдал, Монгол Улсын хөгжлийн төвшинтэй харьцуулан жишин ойлгоход) ... ямар нэгэн байдлаар хэрэгжиж байсан гэж үзэх бүрэн үндэстэй байна» гэх зэрэг сонирхолтой ажиглалт, дүгнэлт хийсэн байдаг.

МОНЦАМЭ мэдээллийн агентлагийн үүх түүхийг хамгийн нэвтэрхий мэдэх, хамгийн сайн судалсан хүн бол яах аргагүй Т.Баасансүрэн. Монголыг дэлхийтэй холбосон энэ том байгууллагын дэд захирал, захирлаар ажиллахдаа бараг судлагдаагүй шахам МОНЦАМЭ-гийн түүхийг бичиж, хэд хэдэн эрдэм шинжилгээний бага хурал зохион

байгуулж, эмхэтгэл гаргасан нь түүний өөрийнх нь бичсэнлэн: «Хаа явсан газрынхаа үүх түүхийг сонирхдог нэг “хобби” надад байдаг»-ийнх нь үр дүн болжээ. Шинээр ажил авч буй дарга нар Т.Баасансүрэн гуайн нэг адил очсон газрынхаа түүхийг юуны түрүүнд сонирхож үздэг, хэрэв хэвлэгдсэн тийм зүйл үгүй бол энэ ажлыг өөрөө гардан эхлүүлдэг заншилтай болмоор санагдсаныг энд зориуд хэлье.

Ардын засаг дөнгөж тогтоод байсан тэр цаг үед Монголын цахилгаан мэдээний агентлаг МОНТА-гаас 1922 оны 5-р сарын 25-наас эрхлэн гаргах болсон «Бюллетень монгольского телеграфного агентства» нь долоо хоногт хоёр удаа орос, монгол хэлээр хэвлэгдэж, уншигчдын гар дээр очдог байв. Монгол Улсын цахилгаан мэдээний агентлагийн анхны хэвлэл төдийгүй, гадаад сурталчилгааны мэргэжиж төрөлжсөн анхны хэвлэл болсон тус сонин сэтгүүл зүйн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсныг судлаач Т.Баасансүрэн тодорхой баримтан дээр тулгуурлаж өгүүлжээ. Тухайлбал, тус сонин «хамгийн бага зайд хамгийн өргөн агуулга, багтаамжтай мэдээллийг цаг мөчтэй уралдан байж цахилгаан мэдээний агентлагийн хэл хэллэгээр шуурхай түгээж байсан», «ашигтай, идэвхтэй мэдээллийн зарчим ... хөдөлбөргүй үйлчилж байсан», «мэдээлэгч, танин мэдүүлж соён гэгээрүүлэгч, удирдлагын хэрэгслийн үүрэг гүйцэтгэгч, зохион байгуулагч, хүмүүжүүлэгч, нийгэм-иргэдийн харилцааны үүрэг гүйцэтгэгч сонин байжээ. Энэ бол өнөөдрийн сэтгүүл зүйд үйлчилж буй үндсэн долоон үүргийн зургааг тус сонин ягштал хэрэгжүүлж байжээ гэсэн үг юм» зэрэг онцлог шинжийг орчин үеийн сэтгүүл зүйн үүрэг, зарчмын үүднээс шүүн өгүүлсэн байна.

«XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл» хэмээх тэргүүн дэвтрийн хоёрдугаар ботид 1922-1923 онд хэвлэгдэн гарсан «Бюллетень монгольского телеграфного агентства»,



«Хураангуй сэтгүүл»-ийн мэдээ, нийтлэлүүдийг бүрэн эхээр нь хавсаргажээ. Аргагүй л судлаач хүний баяр бахдлыг ийн бичсэнээс нь харж болно: «[Эдгээр сонины] шарласан хуудсыг Монголд хуруу дарам цөөхөн хүн өндөгнийхөө үзүүрээр имэрч, өөрийн нүдээр харсан гэдэгт үр эргэлзнэм... Улсын төв номын санд цөөхөн дугаар ганцхан хувь хадгалагдаж байдаг болохоор зориуд

зорин эс очвоос хэн ч үзэх аргагүй юм. Гэтэл тэдгээр дугааруудад Монголын сэтгүүл зүйн шижир алт булаастай байгаа билээ». Тийм ээ, сэтгүүл зүйн шижир алт. Мэддэгт мэргэн цоохор, мэддэггүйд эрээн цоохор гэдэг дээ. Энэ шижир алтыг «ХХ зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл» хэмээх тэргүүн дэвтрийн хоёрдугаар ботиос олж уншиж болно. Үүнийг уншихын тулд заавал суд-

лаач, сэтгүүлч, эсвэл сэтгүүлчийн ангийн оюутан байх албагүй. Эх түүхээ хүн бүр өөрийн хэмжээнд шимтэн судлах үүрэгтэй. Тэгвэл тэр түүх энэхүү ботид байна.

«1921 оны хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил» хэмээх дэд дэвтэр хувьсгалт хэвлэлийн эхийг тавьсан «Монголын үнэн», Монгол дахь намч, ангич хэвлэлийн эхийг тавьж хөгжүүлсэн «Үнэн» сонины тухай өгүүлсний зэрэгцээ БНМАУ-д тогтмол хэвлэлийн систем бүрэлдэн төлөвшсөн онцлог, мөн тогтмол хэвлэлийн нийтлэлийн бодлогыг намаас тодорхойлж, зааварлан чиглүүлж байсан тухай тусгажээ.

«Монголын үнэн» сонины нийтлэлийн эхийг задлан шинжилсэн тайлбар,

дүгнэлтийн хамт хавсаргасан нь судлаачийн байр суурийг ойлгох, цаашлаад хүлээн зөвшөөрөх, магадгүй цэц булаалдах яатай сэжүүрийг гаргаж ирж байна. Зарим нэг задлан шинжилгээ нь нийтлэлээсээ ч дутуугүй хэмжээтэй болсноос судлаач Т.Баасансүрэн ямар их ач холбогдол өгч, сэтгэл шингээн ажилласан нь харагдаж буй юм. Монгол Ардын Намын бодлого,

зорилгыг сурталчилсан, манай улсын түүхэнд анх удаа хувьсгалт, ангич, намч хэвлэлийн эхийг тавьсан «Монголын үнэн» («Үнэн» сонины хамтаар) хэдийгээр зургаахан дугаар гарсан ч тод ул мөр үлдээсэн юм. Энэ талаар судлаач Т.Баасансүрэн: «Монголын үнэн» шиг асар том үр дүн, үр ашигт хүрсэн сонин Монгол Улсын түүхэнд нэг ширхэг ч байхгүй.

Монгол Улсыг Хятад, Оросын эзлэн түрэмгийлэгчдээс чөлөөлж, тусгаар тогтнолоо баталгаажуулан, ард түмнийхээ эрх жаргалант аж амьдралыг тогтооно. Ардын хувьсгалыг мандуулж, хамжлагат ёсыг халж өөрчилнө. Монгол Улсыг олон зууны хоцрогдлоос гаргаж, хөгжил дэвшлийн замд хөтлөн оруулна гэсэн маш тодорхой зорилтыг өмнөө дэвшүүлж тавиад, тэрхүү зорилгоо тавхан сарын дотор амжилттай хэрэгжүүлжээ» гэж зоримог дүгнэлт хийсэн нь эрхгүй анхаарал татаж байна.

«Үнэн» сонины тухай хэсэгт хэдийгээр тус хэвлэл «Монголын үнэн»-ий үргэлжлэл гэгддэг боловч ялгарах онцлог олон байсныг тоочжээ. Гэхдээ

«

*“Нийслэл хүрээний сонин бичиг” нь “Шинэ толь хэмээх бичиг”-ийн нэгэн адил сэтгүүл зүйн ихэнх шаардлагыг хангаж чадсан хэвлэл байсан байна. Үнэн бөгөөд бодитой байх зарчим, хүнлэг бөгөөд энэрэнгүй байх зарчим, ардчилсан хийгээд олон нийтэч байх зарчим, шинэслэх ухааны үндэстэй бөгөөд амьдралтай нягт холбоотой байх зарчим ямар нэгэн байдлаар хэрэгжиж байсан гэж үзэх бүрэн үндэстэй байна.*

»



«Үнэн» сонин «Монголын үнэн»-г шууд залгамжлаагүй бөгөөд энэ хооронд Монгол Ардын Нам, Ардын засаг үүсгэн байгуулж, эрхлэн гаргаж байсан «Уриа», «Нийслэлийн шинэ сонин», «Ардын эрх» хэмээх гурван ч хэвлэл гарч байсан юм. Монголын сэтгүүл зүйн түүхэнд хамгийн олон жил тасралтгүй гарч байгаа «Үнэн» сонин зөвхөн нам, төрийн бодлогыг сохроор ухуулан сурталчлагч төдий байсан мэтээр үзэх нь учир дутагдалтай бол- хыг судлаач олон жишээ, баримтаар харуулжээ.

«БНМАУ-д тогтмол хэвлэлийн систем бүрэлдэн төлөвшсөн нь» хэсэгтээ сэтгүүл зүй судлаачдын анхаарлын гадуур үлдсэн асуудлуудад Т.Баасансүрэн түлхүү ач холбогдол өгсөн байна. Тэгэхдээ төвийн ба салбарын 76, орон нутгийн 22, нийт зуу шахам хэвлэлийн тухай тоймлон өгүүлжээ. Түүнчлэн МОНЦАМЭ мэдээллийн агентлаг, Гэрэл зургийн алба, баримтат кино, Монголын радио, телевиз, FM, арилжааны телевиз, цахим мэдээллийн түүхэн замналын асуудлыг ч хөндсөн байна.

«1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв» хэмээх гутгаар дэвтэр Монголд чөлөөт хэвлэл үүсэхэд нөлөөлсөн хүчин зүйл, чөлөөт ардчилсан хэвлэлийн үзэл санаа, чөлөөт хэвлэлийн хөгжлийн төлөвийг гаргаж иржээ. Хэрэв ХХ зууны Монголын түүхэнд чухал нөлөө үзүүлсэн хоёр үйл явдлын нэг нь 1911-1921 оны тэмцэл болох тухай дээр дурдсан бол удаах нь 1990 оны ардчилсан хувьсгал юм. Нийгмийг үндсээр нь өөрчилсөн аливаа үйл явдал гэнэт гардаггүйн адил ардчилсан хувьсгалын үрийг өөрчлөн байгуулалт тарьжээ. Монголд өөрчлөн байгуулалтын үйл явцыг гүнзгийрүүлж, ил тод байдал, олон ургальч үзлийг дэлгэрүүлж, улмаар улс оронд ардчилсан шинэтгэлийг эхлүүлэхэд Л.Түдэв ерөнхий эрхлэгчтэй «Үнэн» сонин, тэнд ажилладаг сэтгүүлчид ямар чухал үүрэг гүйцэтгэснийг судлаач Т.Баасан-

сүрэн маш баялаг жишээ, баримт ашиглаж дэлгэрэнгүй өгүүлсэн байна. «"Үнэн" сонин ардчилал, шинэчлэлийн салхийг үүсгэн сэвэлзүүлсэн нь» хэсэгт өөрчлөн байгуулалт, ардчилсан хөдөлгөөний эхэн үед сэтгүүлч, нийтлэлчдийн бичсэн 134 өгүүллийг нэр заан дурджээ.

Монголд чөлөөт ардчилсан сэтгүүл зүй үүсч хөгжсөн тухай хэсэгт «чөлөөт» тодотголтой анхны сонинууд болох «Цагийн толь», «Шинэ толь», «Ардчилал»-аас авахуулаад гол гол хэвлэлийн нийтлэлийн бодлого, сэтгүүл зүйн хөгжилд оруулсан хувь нэмрийг түүх бүтээлцэж явсан сэтгүүлчдийн дурсамж, дурдатгалыг өргөн ашиглаж өгүүлсэн байна. Урьд нь судалгаа шинжилгээний ажлын эргэлтэнд орж байгаагүй олон сонирхолтой баримт энэ ботид орсныг тэмдэглэх нь зүй.

**С**удлаач Т.Баасансүрэнгийн анхаарлын гадуур үлдээгүй өөр нэг чухал асуудал бол чөлөөт сэтгүүл зүй, ОНМХ-ийн хууль, эрх зүйн зохицуулалт юм. Учир нь эрх зүйн зохицуулалт хийж өгөлгүйгээр хэвлэл чөлөөтэй байх хөрс нь тавигдахгүй. Энэ асуудлыг судлаач Т.Баасансүрэн Монгол Улсын Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль болон бусад хууль, эрх зүйн актын хүрээнд авч үзжээ. Түүнээс гадна Үндэсний мэдээллийн агентлагийн тухай хууль батлах зайлшгүй шаардлагын үндэслэлийг гаргаж ирсэн юм.

Ихээхэн хөндүүр сэдэв болоод байгаа сэтгүүлчдийн ёс зүйн асуудлыг судлаач Т.Баасансүрэн тойрон өнгөрөөгүй байна. Энэ асуудалд хичнээн их эмзэглэж явдаг, гэхдээ хамгийн гол нь Монголын сэтгүүл зүй жинхэнэ гольдролдоо орж хөгжих цаг ирнэ гэдэгт цагаанаар итгэж явдаг нь мэдрэгдлээ: «Чөлөөт хэвлэл мэдээлэл Монголд цаашид нэр төртэйгээр хөгжин гүнзгийрч чадах эсэх нь Монголын сэтгүүлчдийн өөрсдийнх нь ёс зүйгээс шууд шалтгаалах болно. Сүүлийн хорин жилд



хамгийн аймшигтайгаар хаягдаж орхигдсон зүйлийн нэг бол сэтгүүлчийн ёс зүй юм... Сэтгүүлчийн хувьд хамгаас илүүтэйгээр эрхэмлэн мөрдөж сахих ёстой зүйл нь мэргэжлийн ёс зүй нь мөн. [Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн баталсан ёс зүйн зарчмыг] харамсалтай нь Монголын сэтгүүлчид үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжүүлэхгүй байгаа юм... Тэгэхдээ дандаа ийм байхгүй нь ойлгомжтой. Сайн цаг ирэх болно». Тийм ээ, сайн цаг ирэх болно.

«Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь» хэмээх дөтгөөр дэвтэрт Монголын үе үеийн сор болсон сэтгүүлчдийн охь болсон уран бүтээлийг тоймлон өгүүлж, мэргэжлийн үүднээс үнэлэлт дүгнэлт, шүүмж өгчээ. Монголын сэтгүүл зүйн түүхийг бүтээлцдэг тэдний нэрсийг жагсаахад л хангалттай. Ж.Цэвээн, Б.Ринчэн, Ц.Дамдинсүрэн, Ч.Лодойдамба, Д.Цэвэгмид, С.Дашдэндэв, М.Бизьяа, Өвгөөдэй Дамдинсүрэн, Л.Түдэв, Жа.Пүрэв, Г.Дамба, Д.Намдаг, Ш.Цэрэнпил, Ж.Мягмарсүрэн, С.Мягмар, С.Дашдондов, Ш.Цэен-Ойдов, Ц.Мухар, С.Жамбалдорж, Ү.Хүрэлбаатар, Д.Нямаа, Ц.Намсрай, Х.Цэвлээ, Э.Сонинтогос, Д.Цахилгаан, До.Цэнджав, Б.Золбаяр, Б.Ганчимэг, М.Зулькафиль, Л.Норовсүрэн нарын хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлч, судлаачдын өгүүлэл, бүтээл, ном, судалгааны ажилд голыг нь онож хэлсэн, цөмийг нь базаж гаргасан, ухааж төнхсөн, учирлаж тайлбарласан, ухаарал өгсөн олон шилдэг шүүмж энэ дэвтэрт оржээ. Анх уншаад өнгөхөрөд анзаараагүй зүйл Т.Баасансүрэн гуайн шүүмжийг уншсаны дараа нээрээ л тийм санагдаж, өөр нүдээр дахин харахын тулд эргээд уншиж байсан ч тохиолдол бий. Энэ бол уншсан нь бичсэний хэмжээнд сэтгэж чадаагүйн уршиг. Тэгвэл шүүмж бичихийн тулд

бичсэн хүний хэмжээнд, магадгүй түүнээс ч илүү хэмжээнд сэтгэж, ухаарахгүй бол горьгүй. Гэхдээ энэ ч бас хангалтгүй. Нэг удаа Т.Баасансүрэн гуай «Гурав-дөрөвхөн хуудас шүүмж бичих гэж гурав-дөрвөн зуун хуудас унших хэрэг гардаг» гэж хэлж байсан нь санаанаас гардаггүй. Нэмж хэлэхэд мэдээллийн үерт живж буй өнөө цагт ихэнх уншигч гүйлгэж, эсвэл өөрийн сонирхсон зүйлийг хайх уншдаг, тийм байхад ямар шүүмж гарахав. Ёстой л өнөө цоо уншина гэгч болж байж дуншиж дуншиж нэг шүүмж гарна даа. Тэгэхээр энэ нь ямар их сэтгэл шингээсэн ажил болох нь тодорхой.

Монголын сэтгүүл зүйн дөрвөн зүгт Т.Баасансүрэн дөрвөн хөшөөг өөртөө босгожээ.

Баруун тийш харж сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлээр өөрөө чөлөөтэй туурвина.

Зүүн тийш харж бусдын туурвисан нийтлэл, бүтээлд часхийсэн шүүмж бичнэ.

Урагшаа харж сэтгүүлчдийн бүхэл бүтэн багийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ.

Арагшаа харж, тэрхүү сэтгүүл зүйн түүхийг шинжлэх ухааны үндэстэй бичнэ.

## Резюме

Настоящая рецензия посвящена исследовательской работе известного журналиста, учёного и критика Т.Баасансүрэна. Его пятитомная масштабная работа «Становление независимой, демократической прессы в Монголии» охватывает весь период развития монгольской журналистики, начиная с первой отечественной газеты и кончая современными изданиями. Отличительными чертами исследований Т.Баасансүрэна являются глубокий анализ многочисленных документов и первоисточников, проблемное мышление.